**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Нийслэлийн Баянгол дүүргийн Ашид Амгалан ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/088/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг<br>Утас: 324338, 89116465, 98056465<br>Цахим хаяг: fortune2009audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 797

танай ______________ -ны № ______________ -т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АШИД АМГАЛАН ӨЭМТ-ИЙН ДАРГА Ж.ШИРЧИН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Ашид амгалан ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 376.0 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 147.4 сая төгрөгийн, дархлаажуулалтын зардалд Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас 3.5 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 7.9 сая төгрөгийн, Нийслэлийн эрүүл мэндийн газраас шагналд 5.0 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2025\2026\word\wsab bichig\Dugnelt 2026.docx 1426050907

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Баянгол дүүргийн Ашид амгалан ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/145 дугаар захирамжаар 94.6 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 96.6 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*(төгрөгөөр)*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 29,825,025.74 | 203,916.30 |
| 1.1.2 | Дансны авлага | 31,655,661.53 | 6,420,626.90 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | |
| 1.1.6 | Бараа материал | 950,600.00 | 3,690,267.00 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **62,431,287.27** | **10,314,810.20** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 155,311,652.63 | 123,455,715.28 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **155,311,652.63** | **123,455,715.28** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **217,742,939.90** | **133,770,525.48** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 305,106.77 | 5,970,313.66 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | | |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **305,106.77** | **5,970,313.66** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **305,106.77** | **5,970,313.66** |
| **2.3** | **ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.3.1** | Өмч: а) төрийн | | - |
| 2.3.2 | б) хувийн | 520,000.00 | 520,000.00 |
| 2.3.3 | в) хувьцаат | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 216,917,833.13 | 127,280,211.82 |
| **2.3.11** | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **217,437,833.13** | **127,800,211.82** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **217,742,939.90** | **133,770,525.48** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*(төгрөгөөр)*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 578,581,064.55 | 529,807,092.40 |
| 2 | Борлуулалтын өртөг | 563,493,220.82 | 622,198,568.67 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **15,087,843.73** | **(92,391,476.27)** |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 47,644,800.00 | 24,233,854.96 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | | |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 17,000,000.00 | 21,480,000.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **45,732,643.73** | **(89,637,621.31)** |
| 19 | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **45,732,643.73** | **(89,637,621.31)** |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **45,732,643.73** | **(89,637,621.31)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*(төгрөгөөр)*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **520,000.00** | **173,303,544.55** | **173,823,544.55** |
| 2 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| 3 | **Залруулсан үлдэгдэл** | **520,000.00** | **173,303,544.55** | **173,823,544.55** |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | 43,614,288.58 | 43,614,288.58 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | - |
| 7 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэргжсэн дүн | | | - |
| 8 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **520,000.00** | **216,917,833.13** | **217,437,833.13** |
| 9 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | - |
| **10** | **Залруулсан үлдэгдэл** | **520,000.00** | **216,917,833.13** | **217,437,833.13** |
| 11 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | - |
| 12 | Өмчид гарсан өөрчлөлт | | | - |
| 13 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэргжсэн дүн | | | - |
| 14 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | (89,637,621.31) | (89,637,621.31) |
| 15 | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **520,000.00** | **127,280,211.82** | **127,800,211.82** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*(төгрөгөөр)*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **568,009,921.02** | **571,479,008.03** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | | |
| | Татаас санхүүжилтийн орлого | 567,539,921.02 | 555,042,127.03 |
| | Бусад мөнгөн орлого | 470,000.00 | 16,436,881.00 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **523,551,581.56** | **589,661,617.47** |
| | Ажиллагсдад олгосон | 378,336,848.45 | 312,264,138.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 34,738,778.37 | 83,848,734.57 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 93,475,954.74 | 143,600,398.90 |
| | Татварын байгууллагад төлсөн | | 28,468,346.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 17,000,000.00 | 21,480,000.00 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **44,458,339.46** | **(18,182,609.44)** |
| **2** | **Хөрөнгө оуулалалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **-** |
| | Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | | |
| | Хүлээн авсан хүүгийн орлого | - | |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **37,649,900.00** | **11,438,500.00** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 37,649,900.00 | 11,438,500.00 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | ХО-ын бусад мөнгөн зарлага | - | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(37,649,900.00)** | **(11,438,500.00)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **-** |
| | Бусад орлого | - | |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **-** |
| | Бусад зарлага | | |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-** | **-** |
| | **Валютын ханшийн зөрүү** | | |
| **4** | **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **6,808,439.46** | **(29,621,109.44)** |
| **5.1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **23,016,586.08** | **29,825,025.74** |
| **5.2** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **29,825,025.74** | **203,916.30** |

## 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,135.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 2,300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,835.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*(мянган төгрөгөөр)*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тэтгэмж нэрээр урамшуулал олгож, үүнээс жолоочид олгох 1,200.0 мянган төгрөгийг даргын дансанд, үйлчлэгчид олгох 1,100.0 мянган төгрөгийг нягтлан бодогчийн дансанд тус тус шилжүүлсэн ба 2 ажилтанд цааш шилжүүлсэн эсэх нь баримтаар нотлогдоогүй | 1 | 2,300.0 | 1 | 2,300.0 | | | | |
| Эмч, эмнэлэгийн ажилтнуудын дэмжих сарыг тохиолдуулан тэтгэмж нэрээр 18,350.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо 1,850. мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна. | 1 | 1,835.0 | | | 1 | 1,835.0 | | |
| **Дүн** | **2** | **4,135.0** | **1** | **2,300.0** | **1** | **1,835.0** | **-** | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*(мянган төгрөгөөр)*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 38,153.3 мянган төгрөгийн барилгын материалын 8 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 38,153.3 | | | | | 1 | 38,153.3 |
| **Дүн** | **1** | **38,153.3** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **38,153.3** |